# СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2018 оны 04 сарын 12 өдөр Дугаар А/127 Сүхбаатар сум

Тусгай зөвшөөрөл олгох тухай

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 16.2.5, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 4.3, 4.7, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7.6.1, 9.1 9.2, Захиргааны ерөнхий хуулийн 43.1, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 97 тоот тогтоолоор баталсан "Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх зөвшөөрөл олгох, хяналт тавих журам"-ын 2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хавсралтад заасан аж ахуйн нэгжүүдэд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг 2018 оны 04 дүгээр сарын 12-ны өдрөөс заасан хугацаагаар олгосугай.

3."Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай" хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.2, "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх аймгийн хөтөлбөр"-ийн 3.2.1.5, 3.2.2 2 дахь заалтыг тус тус хэрэгжүүлж ажиллахыг аж, ахуйн нэгж, байгууллагын захирал, дарга нарт үүрэг болгосугай.

3.Тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг аймгийн Цагдаагийн газрын дарга /хурандаа А.Энхбат/, Мэргэжлийн хяналтын газрын дарга /Ж.Отгонхүү/ нарт даалгасугай

ЗАСАГ ДАРГА Ш.ОРГИЛ

Сэлэнгэ аймгийн Засаг даргын
2018 оны 4-р сарын 12-ны өдрийн
А/127 тост захирамжийн хавсралт

/Шинээр авах/

| № | Байршил | Аж ахуйн нэгжийн нэр | Үйлчилгээний газрын нэр | Үйлчилгээний чиглэл | Хугацаа |
|---|---|---|---|---|---|
| 1 | Сүхбаатар | Минжийн бср өтөг ХХК | Буянт хайрхан | Хүнсний дэлгүүр | 2 жил |
| 2 | Алтанбулаг | Загд зүсэм алтан ХХК | Ундрах маркет | Хүнсний дэлгүүр | 2 жил |
| 3 | Мандал | Төгс хараа ХХК | Номин | Хүнсний дэлгүүр | 2 жил |
| 4 | | Ширхэнцэг Буянт ХХК | Хаан | Зоогийн газар | 2 жил |
| 5 | | Нарлаг наранзул ХХК | Нарлаг | Хүнсний дэлгүүр | 2 жил |
| 6 | | Очирваань хишиг арвижих ХХК | Отгонтэнгэр | Хүнсний дэлгүүр | 2 жил |
| 7 | Баянгол | Сэлэнгэ органик маркет ХХК | Органик | Хүнсний дэлгүүр | 2 жил |
| 8 | Ерөө | Ашид тогтуун ХХК | Ашид | Зоогийн газар | 2 жил |
| 9 | | Өлзийтэй ерөө гол ХХК | Оргил | Зоогийн газар | 2 жил |
| 10 | Сайхан | Хөтөл жимсгэнэ ХХК | Хөтөл номин | Хүнсний дэлгүүр | 2 жил |

----- oOo -----